



Ухаалаг Сонголт

ИВЭЭЛ Их Эзэн биднийг мэддэг бөгөөд бидэнд санаа тавьдаг.

Унших Зүйл

Эхлэл 41; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 219-223.

Цээжлэх Ишлэл

"Би үүнийг хийж чадахгүй боловч Их Эзэн чадна" (Эхлэл 41:16).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Бурханд хүн бүрт бэлдсэн онцгой ажил байдаг гэдгийг **мэдэх** болно.

Бурханы биднээр хийлгэхийг хүссэн зүйлийг бид хийхэд Тэр туслах болно гэдэгт **итгэлтэй** байна.

Бурханы төлөө ямар нэгэн онцгой зүйл хийхийг **хүсдэг** болно.

Гол Санаа



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Фараон зүүд зүүдэллээ. Тэр үүнийг чухал гэдгийг нь мэдсэн боловч ямар утгатайг нь ойлгосонгүй. Түүний мэргэн хүмүүс нь ч зүүдийг нь тайлж чадахгүй байжээ. Тэгэхэд дарс аягалагч нь Иосефын зүүд тайлдаг тухай гэнэт санав. Фараон Иосефыг авчруулна. Иосефт зүүд ямар учиртай болохыг Бурхан хэлж өглөө. Фараон Иосефыг ихэд сайшааж түүнийг

шоронгоос гаргаад Египетийн бүх л асуудлыг шийдвэрлэж байхаар ажилд томилдог. Иосеф Их Эзэний төлөө сайныг үйлдэхийг хүссэн учраас Их Эзэн түүнийг ивээжээ.

Энэ бол ивээлийн тухай хичээл

Бидний амьдралд юу төлөвлөснийг нь бид мэдэхгүй ч Их Эзэн аль хэдийнээ төлөвлөчихсөн байдаг. Гэхдээ хэрвээ бид Их Эзэний төлөө ямар нэгэн

АРВАН ХОЁР

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1	Бэлтгэх Ажил	10 минут	А. Их Эзэн Бүтээсэн Б. Боломжтой Даалгавар
*	Залбирал ба Магтаал*	10 минут	127-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал-ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.
2	Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах
			дэр, хөнжил эсвэл том алчуур
			Библи Судлал
			Цээжлэх Ишлэл
			Библи
3	Хичээлээ Заах	15 минут	Гэвч Их Эзэн Чадна
			байхгүй
4	Хичээлээ Хуваалцах нь	15 минут	Иосефын Гинж
			гинжний загвар (148-р хуудас), шар, улбар шар, алтан цаас, хайч, үдээсний машин эсвэл наалт

зүйл хийхийг хүсэж л байвал Тэр бидэнд үүнийг хийхэд маань туслах болно.

Багшийн Баяжуулалт

"Шоронгийн хоригдол байсан Иосеф өөрийгөө Египетийн захирагч болсон гэдэгт ихэд гайхаж байлаа. Энэ үнэхээр нэр хүндтэй албан тушаал боловч бас хийх зүйл нь ч их байв.

... Газар нутгаасаа хол, өөр танихгүй газар байгаа ч гэсэн, Их Эзэнийг хүндэлдэг хүмүүсээс тасарсан ч Иосеф энэ бүх хэргэм зэрэг алдар цуу нь ямар нэгэн нууцлаг гайхамшигт далдын хүчээр хийгдэж байна гэдгийг мэдэж байсан юм. Иосефоор дамжуулан Египетийн хаан Үнэн

Бурхан руу чиглэгдэж өөрсдийн шүтээнээ болгон Ехувагийн хүндэтгэл үзүүлэгч нэгнээс тэд амьдралд хэрэгжиж буй зарчмуудыг сурч авсан". (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 222).

Бид Иосеф шиг Их Эзэн өөрийн хүслээ бидний амьдралыг ашиглан биелүүлэх болно гэж итгэдэг үү? Бид Их Эзэний чиглүүлж буй газарт анхааралтай байж Түүнийг бүрэн сайн сонсож чаддаг уу?

Өрөөний Зохион Байгуулалт

Наймдугаар хичээлд хэрэглэсэн "Хааны өрөө"-г хэрэглэ. 11-р хичээл дээрх "Шорон"-гийн заслыг хэрэглэ.

Заах Хичээл




Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.



А. Их Эзэн Бүтээсэн

Хүүхдүүдэд дараах хурууны хөдөлгөөнийг зааж өг. Тэгээд хэд хэдэн удаа давтаарай.

Нарны гэрлийг хэн бүтээсэн бэ?

Их Эзэн, Их Эзэн бүтээсэн.

Гараараа том тойрог зурах

Гараа өндөрт өргөөд хуруу болон гараа сэгсрэх

Борооны дуслыг хэн бүтээсэн бэ?

Их Эзэн, Их Эзэн бүтээсэн.

Гараа өргөөд бороо орж буй мэт сэгсрээд доош буулгах

Гараа өндөрт өргөөд хуруу болон гараа сэгсрэх

Өвсийг ногоог хэн бүтээсэн бэ?

Их Эзэн, Их Эзэн бүтээсэн.

Гараа газар тавиад өвч ургаж буй мэт гараа сэгсэрч байхдаа дээш болгох

Гараа өндөрт өргөөд хуруу болон гараа сэгсрэх

Салхийг хэн бүтээсэн бэ?

Их Эзэн, Их Эзэн бүтээсэн.

Салхи салхилж байгаа мэт гараа урагш хойш даллах

Гараа өндөрт өргөөд хуруу болон гараа сэгсрэх

Өөрчлөлт: Хүүхдүүд хөдөлгөөн хийх боломжтой өөр олон асуулт асууж хүүхдүүд харин "Их Эзэн, Их Эзэн бүтээсэн" гэж хариулах болно.

Багатгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Салхи салхилах, нар мандах, өвс ургах, бороо орох зэргийг та нар хийж чадах уу? Үгүй, Гэхдээ Их Эзэн чаддаг юм. Бидэнд зарим зүйлийг хийхэд боломжгүй байдаг. Заримдаа бидний хийх ёстой олон хэцүү зүйл байдаг. Хэцүү зүйлийг хийхэд маань Их Эзэн бидэнд тусалж чадна. Өнөөдрийн үзэх Библийн түүх бол зарим хэцүү зүйлийг хийсэн Иосефын тухай юм. Гол санаа:**



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Боломжтой Даалгавар

Юуны өмнө үүнийг давт. Бичгийн цаасаа уртаар нь нугал. Хавсарсан хэсэгт цаасны захаас нэг ямхын хэмжээтэй 9 адил зүсээд, цаасыг эргүүлээд адил хэмжээтэйгээр 8 болгон хуваагаарай. Хуваасан хэсгээ хайчилж авалгүйгээр цаасыг дундуур нь хайчил.

Асуух: **Энэ цааснаас хэн өөрийгөө тасалж авч чадна гэж бодож байна вэ? Би болно гэж та нар бодохгүй байна уу? Чи болох уу?** Нэг хэсэг цаасан дунд тойрог гарган хайчлаад хүүхдэд тохируул үз. **Үүнийг харахад боломжгүй харагдаж байна, гэхдээ харж бай.** Өөр нэг цаас хайчлаад (адил хэмжээний) тохируулж үз.

Хэрэгтэй зүйлс:

- бичгийн цаас 2 ш
- хайч

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Энэ цаасыг тохируулж үзнэ гэхэд боломжгүй санагдаж байсан тийм үү? Заримдаа бидний хийх ёстой олон хэцүү зүйл байдаг. Бид үүнийг хийж чадна гэж боддоггүй шүү дээ. Энэ цаасыг өөртөө тохируулж үзнэ гэхэд чадахгүй мэт харагдах байсан боловч та нар хийсэн байна.**

Ямар нэгэн зүйл хийхэд хэцүү байхад Их Эзэн бидэнд тусалж байдаг. Өнөөдрийн Библийн түүх бол Их Эзэний асуусан хийх ёстой зүйлийг Иосеф хийсэн тухай юм. Хичээлийн гол санаа:





Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Намайг дагаад хэлээрэй.



ТЭМДЭГЛЭЛ: Залбирал ба Магтаал 127-р хуудсанд бий.



2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- дэр
- хөнжил
- эсвэл
- том алчуур

*Хүүхэд бүрт дэр ба хөнжил өг. (Эсвэл том алчуур) Хэлэх: **Намайг зүүд гэж хэлэх үед та нар гараа нийлүүлэн унтаж байгаа мэт толгойныхоо доор тавь. Нааш ирээд "шорон" дотор суу. Иосефын шоронд байсан шиг жүжиглээрэй.***

Түүхийг уншиж эсвэл ярьж болно.

Нэгэн шөнө Иосеф их л сайхан унтаж байлаа. Бүгдээрээ хэвтээд унтаж байгаа мэт дүр эсгэе. Гэнэт, хөлийн чимээ гарлаа. Фараоны зарц нар Иосефын орны хажууд ирээд "Иосеф, бос. Фараон чамайг яг одоо харахыг хүсэж байна. Тэр шөнө нэгэн зүүд зүүдэлжээ. Хэн ч түүнийг нь хэлж чадахгүй байна. Фараоны дарс аягалагч таныг хэлж чадна гэлээ" гэв.

Иосеф тэгэхэд юу хийсэн гэж бодож байна вэ? *[Хариулт сонсох.]* Иосеф босож хувцсаа өмсөөд Фараоны томоос том ордон руу явлаа. *[Хүүхдүүд шоронг орхин суудалдаа суух.]*

Гэвч Иосеф Фараонтой уулзахаас өмнө нэг зүйл хийх ёстой байв. Шоронд, өдөр бүр усанд ордоггүй болохоор тэр бага зэрэг эвгүй үнэртэй байсан байх. Тэр мөн удаан хугацааны турш сахлаа ч хусаагүй бас хувцас нь их заваан байжээ.

Иосефын хийсэн шиг бүгдээрээ цэвэрлэгээ хийж буй мэт дүр эсгэе. Үс болон нүүрээ угаая, цэвэрхэн хувцас өмсөе. Фараоны үйлчлэгч нар Иосефт тусалж түүнийг Фараоны ордонд авчирав. *[Хааны өрөө рүү нүүх.]*

Фараон "Тэд чамайг миний зүүдийг тайлж чадна гэж хэллээ. Энэ үнэн үү?" гэхэд Иосеф толгойгоо сэгсрээд "Үгүй ээ, би чадахгүй. Гэвч Бурхан чадна.

Бурхан таны зүүдний утгыг мэдэж байгаа" гэв.

Фараон Иосефт зүүднийхээ тухай хэлнэ. Эхний зүүдэнд Фараон голын эрэг дээр зогсож байтал цаанаас долоон сайхан тарган үнээ ирж байна гэнэ. *[Зүүн гараа сайхан тарган үнээ гээд төсөөлөөд явуулж үзье.]* Дараа нь долоон туранхай эцэж ядарсан үнээ ирж байна гэнэ. *[Баруун гараараа жүжиглэе.]* Дараа нь юу болсныг тааж чадах уу? Туранхай үнээнүүд тарган үнээнүүдийг залгичихав. *[Баруун гарт байгаа туранхай үнээ зүүн гарт байгаа тарган үнээг залгих, хүүхдүүд таныг дуурайж хийх болно.]*

Гэхдээ юу гээч. Туранхай үнээнүүд тэгсэн ч туранхай л байна гэнэ.

Фараон өөр нэгэн зүүд зүүдэлжээ. Энэ зүүдэнд нь, долоон сайхан толгой тариа будаа харагдаж байна гэнэ. *[Доорх хэсгийг жүжиглэхдээ гараа ашигла. Хуруугаараа тариаг тэгш атгана.]* Тэгээд бас долоон жижиг боодолтой тариа байна гэнэ. *[Нөгөө гараа ашиглана.]* Дараа нь юу болсныг тааж чадах уу? Жижиг долоон боодолтой тариа нь том долоогоо идчихжээ.

Фараон Иосефт "Би мэргэдүүддээ зүүднийхээ тухай хэлэхэд тэд тайлж чадсангүй. Чи чадах уу?" гэхэд Иосеф Фараонд "Их Эзэн танд хэлж байна. Тэр юу хийх гэж байгаагаа таны зүүдэнд хэлжээ. Хоёр зүүд чинь нэг л утгатай. Долоон тарган үнээ нь энэ улсад долоон жил элбэг дэлбэг байхыг, харин долоон туранхай үнээ нь энэ сайн жилүүдийн дараа муу жил ирнэ гэдгийг илтгэжээ.

Энэ бол ган гачиг юм. Хүмүүс өлсөх болно. Хүмүүс сайн жилүүдээ ердөө санахгүй. Бурхан танд үүнийг хэлж байна. Тэгээд та ган болохоос өмнө урьдчилан бэлдэж болно шүү дээ" гэв.

Энэ долоон жилд хүнс хоолыг хянаж байх нэг хүн томилох хэрэгтэй гэдгийг Иосеф Фараонд сануулахад Фараон Иосефыг энэ ажилд томилжээ. Фараон Иосефыг Египетийн бүх л хэргийг шийдвэрлүүлэх албанд тавив. Тэр Иосефт онцгой бөгж болон хувцас хунар өгчээ. Фараон Иосефын хүзүүгээр алтан гинж зүүж өгсөн нь түүнийг албан тушаалд томилсныг илтгэж байна. Тэгээд Иосеф улс орноор явж хоол хүнс бэлтгэн хүмүүст тусалж байлаа.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Фараон Иосефыг дуудуулахад Иосефт ямар байсан гэж бодож байна? Фараон зүүднийхээ утгыг мэдэж байсан уу? Фараоны мэргэн хүмүүс зүүдийг нь тайлж чадсан уу? Фараоны зүүд ямар учиртай болохыг хэн Иосефт хэлж өгсөн бэ? Тэр нь ямар утгатай байсан бэ?**

Фараон Иосефт ямар ажил даалгасан бэ? Хаан ухаалаг сонголт хийсэн үү? Иосеф юу мэдэрсэн гэж бодож байна? Иосефын хийх ажил том ажил байсан уу? Түүнд хэн туслах вэ?

Их Эзэн хийхэд хэцүү зүйл хийхэд чинь чамд ч бас тусалдаг. Тэр үргэлж чамтай хамт байж, тусалж хайрлаж байдаг. Гол санаагаа санаж байна уу?



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библийнхээ Эхлэл 41-р бүлгийг гарган "Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн маань энэ хэсэгт байна" гээд ишлэлийг чангаар унш.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Иосефыг шоронд байхад дарс аягалагч өөрийг нь мартчихсан гэж бодож байна уу? Иосефын тухай хэн мартаагүй вэ? (Их Эзэн). Их Эзэн чамайг ч мөн хэзээ ч мартдаггүй.**

Фараоны зүүдийг тайлахад нь хэн Иосефт тусалсан бэ? Иосефт шинэ ажлаа хийхэд нь хэн тусалсан бэ?

Их Эзэн чамд хэцүү ажил хийх хэрэгтэй үед чинь туслах болно. Санацгаая:



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библиэ нээгээд Эхлэл 41:16-г гарган "Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна" гээд

ишлэлийг чангаар унш. "Би үүнийг хийж чадахгүй боловч Их Эзэн чадна." Тэгээд цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг зааж өг.

Би Өөрийгөө заах.




үүнийг хийж чадахгүй боловч Хуруугаа үгүй гэсэн маягтай хөдөлгөх.



Их Эзэн чадна. Дээшээ заагаад толгойгоо дохих.



Эхлэл 41:16 Алгаа нийлүүлээд дэлгэнэ.



3

Хичээлээ Заах

Гэвч Их Эзэн Чадна

Хүүхдүүдийг тарааж зогсоо. Хэлэх: **Одоо бүгдээрээ юу хийж чадахаа харцгаая. Миний хэлсэн зүйлийг хийж чадах бол хийгээрэй. Хэрвээ чадахгүй бол "Үгүй, Гэвч Их Эзэн чадна" гэж хэлцгээе.**

Хэлэхдээ хөдөлгөөнийг хийгээрэй.

Гурван удаа үсэрч чадах уу?
Инээмсэглэн хөхөрч чадах уу?
Нарны гэрлийг хийнэ үү?
Үгүй, гэвч Их Эзэн чадна.

Хөлийнхөө хуруунд хүрч чадах уу?
Баярлалаа гэж хэлж чадах уу?
Борооны дуслыг хийж чадах уу?
Үгүй, гэвч Их Эзэн чадна.

Эргэж чадах уу?
Алгаа ташиж чадах уу?
Өвс ургуулж чадах уу?
Үгүй, гэвч Их Эзэн чадна.

Чихэндээ хүрч чадах уу?
Хажуу тал руугаа нугарч чадах уу?
Салхи салхилуулж чадах уу?
Үгүй, гэвч Их Эзэн чадна.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Та нарын хийх дуртай зарим зүйл чинь юу вэ? Яагаад? Чи олон зүйл хийж чадах боловч зарим зүйлийг хийж чадахгүй. Туслалцаа хэрэгтэй байдаг зүйл чинь юу вэ?** (Гутлаа үдэх, дугуй унах, өндөр тавиурт хүрэх, ороо засах гэх мэт.)

Ээж аав ч бас зарим зүйлийг хийж чаддаггүй, гэвч Их Эзэн чадна. Зөвхөн Их Эзэн л хийж чадах зарим зүйл юу вэ?

Тоглож байгаа тоглоомонд чинь хөрш чинь түрүүлэх, тоглоомоо бусадтай хуваалцах, инээмсэглээд хурдан үгэнд ордог байх гэх зэрэг Бурханы биднээр хийлгэхийг хүсдэг хэцүү зүйл заримдаа тохиолддог. Чамд тохиолдож байсан хийхэд хэцүү зүйл чинь юу вэ? Их Эзэн үргэлж чамтай хамт байх бөгөөд хэцүү зүйлийг хийхэд чинь тусалж байдаг. Хичээлийн гол санаа бол:



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Намайг дагаад хэлээрэй.

4

Хичээлээ Хуваалцах нь

Хэрэгтэй зүйлс:

- гинжний загвар (х.148)
- шар, улбар шар эсвэл алтан шар өнгийн цаас
- хайч
- үдээсний машин эсвэл наалддаг цаас

Иосефын Гинж

Юуны өмнө, хүүхэд бүрт зориулан шар улбар шар эсвэл алтан шар өнгийн цаасан дээр гинжний загвар зураг (148-р хуудас) хийж өгөөрэй. Гинжийг хайлчлан аваад 16 хэсэгт нугал. Захиас үг болон

цээжлэх ишлэлийг тусгаарлахын тулд хоёр хоёр хоосон цаас үлдээгээрэй.

Хэлэх: **Та нар цаасаар гинж хийх гэж байна. Та нарыг цаасан гинж хийгээд цээжлэх ишлэлээ үг бүрээр нь нэг нугалаас дээр бичихэд чинь бид туслах болно. Цээжлэх ишлэлээ бичсэнийхээ дараа нэг хоосон цаас үлдээгээрэй.**

Гол санаагаа бичиж дууссаны

дараа хоосон зай үлдээгээд үд.
Ингээд бүтэн гинж гарч ирэх болно.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой:
Энэ гинж нь та нарт **Фараон Иосефт** ажлаа хийж эхлэхэд нь өгсөн алтан гинжийг санагдуулах байх. Үүнийг гэртээ авч очоод хэн нэгэнтэй хуваалцаж Иосефыг хүнд ажил

хийхэд нь **Бурхан хэрхэн тусалсан тухай ярьж өгөөрэй.** Хэрвээ чи Түүнээс гуйх л юм бол Тэр чамд туслах болно. Хичээлийн гол санаагаа бүгдээрээ сүүлийн удаа хамтдаа хэлцгээе:



Их Эзэн бидэнд юу ч хийхэд туслах болно.

Хичээлийн Хаалт

Нэг хүүхдээр залбируулаарай. Хүн бүрт сайхан долоо хоногийг ерөөгөөд үзсэн түүхээ гэр бүлтэйгээ хуваалцахыг нь сануулаарай.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

- "Тэр бол боломжтой" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 93*)
- "Есүс хэзээ ч ялагдашгүй" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 108*)
- "Миний Эзэн үнэхээр гайхамшигтай" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 112*)
- "Бахархалын дуу" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 74*)
- "Есүс надад хайртай" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 102*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй.

Хандив

Хэлэх: **Их Эзэн бидэнд юу ч хийхэд тусалж чадна. Бидний хийж чадах нэг зүйл бол бусадтай өргөлөө хуваалцах юм.**

Залбирал

Хүүхдүүдийг том хүнтэй хос болго. Бурханд талархахаар хос бүрт амьтан, гэр бүл, хоол хүнс, ор, нарны гэрэл зэрэг зүйлийн зургийг өг. Зурган дээр байгаа зүйлийн төлөө тэд Бурханд талархах болно.

* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

Ухаалат Сонголт

Унших Зүйл

Эхлэл 41; Эцэг
Өвгөд ба
Зөнчид, х. 219-
223.

Цээжлэх Ишлэл

"Би үүнийг хийж
чадахгүй боловч
Их Эзэн чадна"
(Эхлэл 41:16).

Гол Санаа

**Их Эзэн бидэнд юу
ч хийхэд туслах
болно.**

Танд хийх ёстой хэцүү зүйл тохиолдож байсан уу? Иосефт Фараоны зүүдийг тайлах хүнд ажил оногдсон боловч тэр үүнийг ганцаараа хийгээгүй юм.

Нэгэн өглөө ордны цонхоор гэрэл тусан Фараон сэрлээ. Түүний толгой өвдөж тэр нэг л сайн унтаж чадсангүй. Тэр их сонин зүүд зүүдэлжээ. "Бүх мэргэдүүдийг авчир" гэж зарцдаа хэлэв.

Мэргэдүүд бүгд хааны зүүдийг сонсоод "Бид хэлж мэдэхгүй юм байна" гэж толгой сэгсрэн шивнэлдэн зогсоно.

Гэнэт Фараоны дарс аягалагч урагшаа алхан "Намайг хоёр жилийн өмнө шоронд байхад Иосеф гэдэг залуу эр миний зүүдийг тайлж өгсөн юм. Бүх зүйл яг тэрний хэлснээр болсон" гэлээ.

Фараон үүд рүү заагаад "Түүнийг авчир" гэв.

Зарц нар шорон луу яаран Иосефыг усанд орж хувцсаа солихыг хүлээгээд түүнийг хурдхан шиг хаан дээр авчирлаа.


"Би нэгэн зүүд зүүдэллээ, энд байгаа хэн ч надад утгыг нь хэлж чадахгүй байна. Ямар утгатай болохыг нь хэлээд өгөөч" гэж Фараон хэлэхэд Иосеф "Би таны зүүдний утгыг тайлж чадахгүй ээ. Харин Эзэн Бурхан надад хэлэх учир би танд дамжуулъя" гэв.

"Би голын хажууд зогсож байтал долоон тарган үнээ өвс идээд цаанаас гараад ирлээ. Бас долоон туранхай үнээ гарч ирээд долоон тарган үнээг идчихсэн. Бас нэг зүүдэнд минь

долоон сайхан бүдүүн багцтай тариаг долоон жижиг багцтай тариа идчихсэн" гэж зүүдэллээ.

"Хоёр зүүд нэг утгатай. Бурхан танд хэлж байна. Одоо долоон жил элбэг дэлбэг амьдрах боловч дараа нь долоон жилийн өлсгөлөн бий болох

юм байна. Та нэг хүнийг хоол хүнсний асуудал хариуцуулахаар томилсон нь дээр юм байна. Тэр хоол хүнсийг нөөцлөн өлсгөлөн болох үед тараан өгөх болно" гэж Иосеф хэлэхэд Фараон Иосефын санааг дэмжин бөгжөө тайлан хуруунд нь зүүж хүзүүгээр нь том алтан гинж зүүлээ. "Одоо чи Египет



улсын газар нутгийг хариуц. Чи энэ улсад миний дор байх хамгийн дээд хүн" гэж Фараон хэллээ.

Тэгээд Иосеф шинэ ажлаа эхэллээ. Тэр гадуур дотуур яван хоол хүнс бэлтгэж байв. Үржил шимтэй жилүүдэд тариа будаа тарьж нөөцөлж байлаа.

Иосеф дахин шоронд ороогүй ээ. Тэр хааны төлөө ажилласан. Гэвч Иосеф нэг зүйл ижил байгааг олж мэджээ. Түүнийг шоронд байхад Бурхан яаж асарч байсан шиг ордонд ч мөн харж хандсаар байх болно гэдгийг мэдэж байлаа.

Дасгал Ажил

Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр Библийн түүхийг уншиж, цээжилсэн ишлэлээ хамтдаа давтаарай.

БиӨөрийгөө заах.

үүнийг хийж.....Хуруугаа үгүй гэсэн чадахгүй боловч маягтай хөдөлгөх.

Их Эзэн чадна.....Дээшээ заагаад толгойгоо дохиx .

Эхлэл 41:16Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Хамтдаа Эхлэл 41-г уншаад асуух нь: Дарс аягалагч суллагдсаны дараа Иосеф шоронд хэр удаан байсан бэ? Иосеф Фараонд дуудагдахдаа ямар байсан гэж бодож байна вэ? Фараон Иосефоор юу хийлгэхийг хүссэн бэ? Тэр хийж чадсан уу?

Даваа

Гурван удаа үсрэх, хөлийнхөө хуруунд хүрэх, гэдсээ цохих, эргэх, таван удаа нүдээ ирмэх, эвшээх зэрэг үйлдлийг хүүхдээрээ хийлгэ. Дараа нь тохойгоо уруулдаа хүргэхийг асуу. Асуух нь: Чи яагаад үүнийг хийж чадахгүй байна вэ? Хэцүү зүйл хийхэд чинь хэн чамд тусалж чадах вэ?



Залбирлынхаа өмнө "Миний Эзэн үнэхээр гайхамшигтай" дууг дуул.

Мягмар

Шаббат хичээл дээр хийсэн Иосефын гинжийг хэн нэгэнтэй хуваалцаж түүнд цээжлэх ишлэл

болон түүхийг ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл 8 хэсэг цаас хайчлаад, цаас бүр дээр цээжлэх ишлэлээ нэг нэг үгээр нь бич. Хүүхдээрээ цааснуудыг хооронд нь үдүүлээд гинж хийлгэ.)

Лхагва

Хүүхдээсээ асуух нь:

Чамд хийхэд амархан зүйлүүд чинь юу вэ?

(Гүйх, дуу дуулах, 10-ын дотор тоолох, үсрэх гэх мэт.)

Одоо хийхэд хэцүү байгаа боловч том болоод хийж чадах зүйл чинь юу вэ?

(Гутлаа үдэх, өндөр тавиурт хүрэх, унших, 1000-ын дотор тоолох гэх мэт.) Энэ зүйлүүдийн аль нэгийг хийхэд хүүхдэдээ туслаарай. Тэдэнд хэцүү зүйл хийхэд нь Бурхан тэдэнд тусална гэдгийг сануулаарай.



Пүрэв

Гэр бүлийнхээ гишүүдээс тэд бие биедээ тусалж чадахааргүй үед Их Эзэн тэдэнд хэрхэн тусалсан тухай асуу.

"Есүс надад хайртай" дууг дуулаад залбир. Хэцүү үед тусалж байдагт нь Бурханд талархаарай.

Баасан

Сандал болон хөнжил ашиглан шоронгийн өрөө шиг засал засаарай. Түүхийг жүжиглэн хүүхдээ Иосефын дүрд тоглуулан Фараоныг дуудах үед шоронгоос гаргана. Их Эзэн биднийг хэрхэн халамжилдаг тухай ярилц.

"Тэр бол боломжтой" дууг дуулаад сайн зүйл хийхийн төлөө биднийг өсгөж том болгож байгаад нь Бурханд талархаарай.